



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/655

Номгон

Коронавирусын халдвараас урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх аян зарлах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, аймгийн Онцгой комиссын 67 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын нэгдсэн шуурхай штабын даргын 2021 оны 10481 дугаар албан бичгийн дагуу коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд "Дархлаажуулалтандаа хамрагдаж, эрүүл мэндээ хамгаалцгаая" аяныг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нэгдсэн хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Дээрх аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус аймгийн нийт иргэд, олон нийтийг хамруулан зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт, үйл ажиллагаа зохион байгуулах явцад үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (Хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

60110539

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар
сарын 22-ны өдрийн 1/65 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

КОРОНАВИРУСЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЯНЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Наранбаяр (Аймгийн Засаг
даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Азбаясгалан (Аймгийн Засаг
даргын Тамгын газрын Соёлын
хэлтсийн дарга)

Д.Балжмаа (Эрүүл мэндийн газрын
Нийгмийн эрүүл мэндийн төвийн
дарга)

Н.Бямбадорж (Мэргэжлийн
хяналтын газрын дарга)

Ц.Энхтөр (Боловсролын газрын
дарга)

Н.Мэндбаяр (Гэр бүл, хүүхэд
залуучуудын хөгжлийн газрын
дарга)

М.Мөнгөнцэцэг (Улаан Загалмайн
хорооны дарга)

Нарийн бичиг:

Б.Алтанчимэг (Эрүүл мэндийн
газрын Дархлаажуулалт бүхий
халдварт өвчний асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1165 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

КОРОНАВИРУСЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5
1	Дархлаажуулалтыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргах	2021.10.27	Б.Наранбаяр (АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)	Эрүүл мэндийн газар
2	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хуралдуулж, дархлаажуулалтын ажлын төлөвлөгөөг танилцуулах			
3	Сумдын Засаг дарга нарт дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх албан бичиг хүргүүлэх	2021.10.27	Ажлын хэсэг	Онцгой байдлын газар
4	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр дархлаажуулалтын талаар мэдээлэл, шторк бэлтгэн тогтмол дамжуулах	Өдөр бүр	Д.Балжмаа (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга)	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд
5	Үйлчилгээний төвүүдэд дархлаажуулалтын хэвлэмэл хуудсуудыг байрлуулах	2021.10.27- 2021.11.01		Мэргэжлийн хяналтын газар
6	Төв замын самбарт хулдаасан хэвлэл байршуулах	2021.10.27- 2021.11.01	Ажлын хэсэг	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд
7	7 хоног бүр дархлаажуулалтын нэгдсэн мэдээг Улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комисст хүргүүлэх	7 хоног бүр	Ажлын хэсэг	Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб
8	Тайлан, мэдээг нэгтгэж, үр дүнг аймгийн Онцгой комисст танилцуулж, Улсын Онцгой комисст хүргүүлэх	2021.12.31	Ажлын хэсэг	